



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠭᠢᠨ
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠲᠦᠨ
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2022 оны 12 сарын 14 өдөр

Дугаар А/788

Алтай хот

Элсэлтийн ерөнхий шалгалтад амжилт үзүүлсэн багш нарыг урамшуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.3.1 дэх заалт, “Боловсролын чанарыг сайжруулах” хөтөлбөрийн 7 дугаар зүйлийн 3.1.6 дахь заалт, 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг, Засаг даргын Удирдлагын зөвлөлийн 2022 оны 43 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Элсэлтийн ерөнхий шалгалтад амжилт үзүүлсэн багш нарыг урамшуулж хавсралтаар баталсугай.

2.Урамшуулалд шаардагдах 1,000,000 (нэг сая) төгрөгийг элсэлтийн ерөнхий шалгалтад амжилт үзүүлсэн багш, сурагчдыг урамшуулах батлагдсан зардлаас гаргахыг Боловсрол, шинжлэх ухааны газар (Ж.Амгаланбаатар)-т зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтийг хангаж, хөрөнгийн зарцуулалтыг тайлагнан ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны газар (Ж.Амгаланбаатар)-т үүрэг болгосугай.


4.Захирамжийн хяналт, гүйцэтгэл, санхүүжилтэд хяналт тавьж ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Х.Баатарзориг), Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Л.Хаш-Эрдэнэ), Нийгмийн бодлогын хэлтэс (С.Мөнхжаргал)-г тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР

Аймгийн Засаг даргын 2020 оны
82 дугаар сарын 14 ны өдрийн 23 дугаар
захирамжийн хавсралт



ЗАРДЛЫН ТООЦОО

д/д	Сургууль	Овог	Нэр	Мөнгөн дүн
1	Ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн дуу хөгжмийн багш	Түвшинжаргал	Атарцэцэг	500,000
2	Дэлгэр сумын ЕБС-ийн биеийн тамирын багш	Балжир	Мөнх-Эрдэнэ	500,000

__оОо__